

ХҮННҮ БОЛОН ЗАРИМ ХҮННҮ ОВГИЙН НЭРИЙН СУДАЛГАА

БАРАНГАСЫН БАТСҮРЭН

МУИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор

Хураангуй. Хүннү хэмээх нэр бол Хүннү гүрнийг байгуулахад гол үүрэг гүйцэтгэсэн *жинхэнэ хүннүчүүдийн* угсаа хамаарлыг нэг тал руу шийдэхэд хамгийн чухал баримт болно. Тиймээс энэ нэрийн учир утгыг олж тайлбарлах гэж эрдэмтэд эртнээс оролдсоор иржээ. Гадаадын эрдэмтэд *жинхэнэ хүннүчүүдийг* түрэг хэлтэн байсан гэж бат итгэлтэйгээр харж ирсэн тул нэрийг нь тайлбарлах гэсэн тэдний санал, үзлүүд бүгд мухардсан гэж болно. Харин монгол судлаачид тус үгийг хүн/хүмүүн гэх үг хэмээн итгэх тул жинтэй судалгаа хийлгүй өдий хүрчээ. Хүннү хэмээх нэрийн талаарх бидний судалгаа нэгд, тус галиг/үгийн хоёрдугаар үе *-ну*-г харгалзан үзсэнээрээ онцлогтой. Хоёрт, эрдэмтдийн сэргээсэнчлэн *-a/-na*-г бус харин **nra(t/d)/*ra(t/d)* гэх үеийн галиг байжээ гэж үзсэн юм. Ингэснээр, орчин цагийн дуудлагаар Хүннү гэж уншигдах эртний галигийн цаана монгол сурвалжийн мэдээгээр VIII-XIII зуунд найдвартай хэрэглэгдэж байсан Хонгират/Хонгирад гэсэн угсаатны нэр нуугдаж байсан байна.

Түлхүүр үг: Хүннү, Люаньти/Сюйляньти, Хуянь, Лань, Сюйбу, Цюлинь

Түүхийн судалгааны хэрэглэгдэхүүн нь өөрөө олон янз, шавхагдашгүй байсаар ирсэн. Харин судлаач нар хэрэглэгдэхүүнээ судлахдаа зөв хандлага тогтоох¹ явдал чухал бөгөөд зайлшгүй шаардагдах эхний алхам болдог. Ингэж, маш анхааралтай хандаж, болж өгвөл ихэнхэд нь, амжилгүй бол цөөн тохиолдолд ч гэсэн болж л өгвөл зөв чиглэл баримтлахыг шаарддаг сэдвийн нэг нь *монголчуудын* угсаа гарваль, ялангуяа эртний нүүдэлчид, овог, аймгуудын угсаа хамаадал болохыг судлаачид хэлүүлэлгүй мэдэх байх. Төв Ази, Монгол оронд нутаглаж байсан эртний нүүдэлчдийн угсаа хамаадлыг магадлан шинжихдээ юуны өмнө угсаатны бүлэг нэгжийг бусдаас ялгах шалгуур болсон, эрдэмтдээс аль болох боломжит түвшинд нь судлан тогтоосон хам шинжийг үндэслэж

¹ Нямдорж Ү. Түүхийн судлал ба түүний аргазүйн зарим асуудал – *SH*. Том. XXV, Fsc. 3. УБ., 1990, т. 29

судалгаа явуулах нь арга зүйн хувьд зөв хандлага болов уу.

Л.Х.Морган, Ф.Э.Энгельс нараас эхтэй XIX зууны өрнөдийн «нийгмийн хувьслын онол» цаашид марксист (ө.х. зөвлөлтийн) болон өрнөдийн (ө.х. барууны) нийгмийн ухааны гэж хоёр салбарлаж, хөгжжээ.² Харин энэ хоёр салбарын нэг чиглэл *зөвлөлтийн нийгмийн ухааны* чиглэлийн төлөөлөгч Ю.В.Бромлей угсаатны нэрийн судалгааг чухалчилж үзсэн ба тэрбээр, алив бодгалийн өөрийгөө аль нэг угсаатанд хамаатуулах хамгийн энгийн илэрхийлэл бол *угсаатны нэр* бөгөөд бас хамгийн нүдэнд үзэгдэм, ил тод угсаатны шинжийн нэг юм³ гэж бичжээ.

Түүхийн судалгаанд ч мөн адил угсаатны нэрийн шинжилгээ чухал тул түүхчид угсаатны нэрийг “түүхийн талаар нарийн нягтлах нь зайлшгүй чухал” гэдгийг онцолж тэмдэглэсээр ирсэн.⁴

Угсаатны нэр нь тухай тухай үедээ үүсэн бий болгож, хэлбэржүүлсэн, олон үе дамжин тогтвортой оршиж чадахуйц болсон тэр л бүтэц, бүтцийн араг яс, гагнаасны хамгийн товч илэрхийлэл. Гагнагч, цөм араг яс нь овгийн эзэд байж, харин тэд оршин буйгаа, тусгаар байгаагаа угсаатны нэрээр зарлаж, харуулж, түүний хүчээр үеэс үед оршиж байсан учир угсаатны нэрийн судалгааг чухалчилж үзэхээр болсон юм. Өнөөдөр ч гэсэн эрдэмтэд бараг л угсаатны нэрийг үндэслэж тэртээ цаг үеийн овгуудыг ийм тийм угсаатан байжээ гэж үздэг.

Угсаатныг тодорхойлогч шинжүүдээс “угсаатны нэр”-ийг шинжилдэг талбарыг сонгож авсан шалтгаан нь монголын эрт, дундад эртний нүүдэлчдийн түүх-угсаа хамаадлын судалгааны онцлогоос шууд хамааралтай. Түүнчлэн “угсаа гарвалын судалгаанд нэрийн гарал үүсэл, хувирал, хадгаламжийн асуудал”⁵ анхаарал татсаар ирсэнтэй уялдана.

Эрдэмтэд *угсаатны нэр* → *угсаа хамаадал* гэх дараалалт судалгааг хийсээр ирсэн. Угсаатны нэгжийн *угсаатны нэрийг* судалж тодорхой хэлний бүлэг, аль нэг угсаатанд хамаатуулсан ажлын жишээгээр Лайош Бэшэ (Lajos Bese, 1926-1988)-ийн өгүүллийг нэрлэж болно. Тэр, XIII зууны зарим монгол овог, аймгийн нэрийг судалж, олонхий нь түрэг үг гээд, тэдгээр овог, аймгийн угсаа хамаадлыг *түрэгүүдэд* хамаатуулсан билээ.⁶ Монголд ч ийм судалгаа хийгдсэн.⁷

Дурдсан жишээ бол угсаатны нэрээр дамжуулж угсаатны олон бүлэг нэгжийн угсаатны хамаарлыг тогтоохыг зорилго болгосон дагнасан судалгааны жишээ. Ийм зорилгоор бус дам байдлаар асуудал хөндсөн янз бүрийн түвшин, хэмжээний судалгаа олон байдаг ба тэдгээрийн дотор үнэнд дөхсөн нь ч байхад

² Дэлгэржаргал П. Дундад эртний монголын овгийн судалгаа ба өнөөгийн чиг хандлага – *АН*. Том. XVII, Fasc. 7, УБ., 2016, т. 69-79

³ Бромлей Ю.В. *Этнос и этнография*. М., 1973, стр. 98

⁴ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 196

⁵ *Эрт, дундад үеийн монголчуудын аж ахуй, соёл*. УБ., 2006, т. 11

⁶ Bese L. On Some Ethnic names in 13th century Inner-Asia – *АОН*. Том. XLII, Fasc. 1, Budapest, 1988, pp. 17-42

⁷ Арга барил нь дэндүү адилхан хоёр судалгаа олны хүртээл болсон байдаг, тухайлбал, А.Очир, Ж.Гэрэлбадрах нарын нэг сэдэвт зохиол болон өгүүлэл энэ чиглэлд багтана. Өөрөөр хэлбэл, энэ гурван судлаач нь аль тааралдсан, таалагдсан хэлний үгээр угсаатны нэрийг тайлбарласан юм.

зарим нь илэрхий гуйвуулж гажуудуулсан, бүр маш хөнгөн хуумгай хандсан тохиолдол ч олон байна.

Угсаатны нэрийг судлах нь олон шинжлэх ухаанд ач холбогдолтой, гол судлагдахууны нэг болдог чухал хэрэглэгдэхүүн байдаг гэнэ. Тэгээд ч орчин цагийн тодорхой нэг улсын нутаг дэвсгэрт эрт цагт ямар ард түмэн, угсаатны бүлэг нутаглаж байсан, угсаатны нэр нь юу билээ? гэдэг сэдэв түүхийн судалгааны гол чухал асуудал болох ба угсаатны нэр дандаа түүхээр нөхцөлдсөн байдаг тул тэр хэрээр түүхийн үнэт гэрч болдог.⁸

Мал аж ахуй суурьтай иргэншилт эртний ард түмнүүдийн угсаа-хэлний хамаарлыг хөдөлбөргүй, найдвартай гэрчилдэг баримт ховор байдаг учраас зарим тохиолдолд угсаатны нэр цор ганц хэрэглэгдэхүүнд тооцогддог. Тиймээс судалгаа өнгөрсөн үе рүү улам нэвтэрч, одоо цагаас холдох тусам угсаатны нэр гол баримт болох магадлал нэмэгдэх хандлагатай холбогдон угсаатны нэрийн судалгаа чухалд тооцогдож, тэр хэрээр анхаарал татдаг.

ХҮННҮ *q^hoŋ.nra<ɣ>

I. “Хүннүгийн удам угсаа[ны] асуудал бол *монголчуудын* гарал үүсэл, түүхэн хөгжлийг тодорхойлох явдалтай нягт холбоотой [ялангуяа] *хүннүгийн* угсааг тодорхойлох явдал *монголчуудын* үүслийг олж мэдэхэд маш чухал”⁹ гэж Н.Ишжамц 1956 онд хэлж байжээ.

Үнэхээр ч *хүннүчүүдийн* угсаа хамаадал бол *монголчуудын* угсаа гарлын асуудлыг шийдвэрлэхэд үлэмж нөлөөтэй, гол сэдэв мөнөөс мөн. Тиймээс *хүннүтэй* холбоотой бүхнийг болж өгвөл бүгдийг нь хамж, их өндөр хувьтай маш нягт нямбай, шүүлтүүр тунгаалтайгаар судлан тогтоох явдал үе үеийн түүхчдийн нэн тэргүүнд барьж шийдвэрлэвэл зохилтой асуудал билээ.

Хүннү гэх үгийн, галигийн уг хэлбэрийг аль болох үнэнд дөхүүлж тогтооход эн тэргүүнд эл нэрийг зүүгчдийн хэл-угсааны хамаарлын талаарх саналууд баримжаа, дэвсгэр суурь болно.

XVIII зууны түүхч Рашпунцаг *хүннүчүүдийг монголчуудын* дээд өвөг мөн гэж үзэж байв.¹⁰

Түүний саналтай ижил үзэл баримтлалыг цөөнгүй гадаад эрдэмтэн тухай, тухайн цагтаа дэвшүүлж байлаа. Жишээ нь, хятад сурвалжийг өрнөдийн хэлэнд орчуулагч нарын анхдагчийн нэг Н.Я.Бичурин, англи хэлээр нүүдэлчдийн цогц түүх бичсэн Х.Ховорт нар ингэж үзэж байжээ.¹¹ *Сяньбичуудын* өмнө нэр гарсан, баруун талынх нь хөрш болох *хүннүчүүдийг* Пельо *монгол* угсаатан хэмээн үзсэн гэж 1926 онд Стамбулийн их сургуульд уншсан лекцдээ В.В.Бартольд хэлсэн

⁸ *Этнонимы*. Ответственны редактор В.А.Никонов. М., 1970, стр. 3

⁹ Ишжамц Н. Хүннүгийн удам угсаа, нийгэмлэгийн байгуулал – *Академич Н.Ишжамцын бүтээл туурвил*. Тэргүүн дэвтэр. Эмхэтгэн хянан тохиолдуулсан И.Саруул, Д.Шүрхүү. УБ., 2010, т. 21, 22

¹⁰ Рашпунцаг. *Болор эрих*. Тэргүүн дэвтэр. Хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн. УБ., 2006, т. 15

¹¹ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 153

бол *хүннүчүүдийн* хэлэнд өвөг монгол хэлний махбодь (Proto–Mongol element) байсан¹² гэдэгт дорно, өрнийн хоёр нэрт эрдэмтэн К.Ширатори, П.Пеллио хоёр итгэлтэй байсан гэж хамгийн тууштай түрэгчдийн (тюркологич) нэг У.Самолин 1957 онд бичсэн байдаг.¹³

Хэдийгээр Н.Я.Бичурин, К.Ширатори, П.Пельо (Пеллио) нарын нэр өндөр гадаадын эрдэмтэд *хүннү–монголчуудын* удмын холбоог хүлээн зөвшөөрдөг ч дийлэнх эрдэмтэн *хүннүг* зүгээр *түрэгийн* дээдэс гээд шууд итгэчихдэг хачин зуршлаа XIX зуунаас одоог хүртэл гээлгүй, тууштай дагасаар байгаа. Олонд хүндтэй хийгээд хүннүтэй холбоотой аливаа асуудлыг бүр хэт түрэгжүүлж авч үздэг эрдэмтэн нараас дурдвал – Абель-Ремюза, Ю.Клапрот, Ф.Хирт, О.Прицак, У.Самолин, Ж.Клосон, Н.Аристов, В.А.Панов, А.Н.Бернштам, Ю.А.Зуев нар болно. Жаахан дэгсдүүлбэл, тэдний нэрийг тоочиж дуусахгүй үргэлжилсээр байх болно.

1944/45–1963 онд *хүннүг* кет (О.Мэнчен-Хелфен), эсвэл иран (Э.Мүүр) хэлтэн байсан гэдэг онол гарч Л.Лигети, Э.Ж.Пуллиблэнк, А.П.Дульзон, А.Вовин болон Х.Бэйли, Я.Харматта нар дэмжжээ.

Хүннү гэсэн галиг (үг)-ийг монгол, түрэг эсвэл кет, иран гэсэн 4 хэлийг баримжаалж тайлбарладаг урсгал байгаа ч хэл, түүхийн чиглэлийн судлаачдын бичиж тэмдэглэснээр бол *хүннүчүүд* нь кет эсвэл иран хэлтэй байсан гэдэг нь үл батлагдах онол болох нь үндсэндээ тогтоогдсон. Харин ямар ч нотолгоогүй, баримтлагч нар нь өөрсдөө л шууд итгэчихдэг *хүннү бол түрэг хэлтэн* гэх онолоор Хүннү нэрийг тайлбарласан судалгаа олж хараагүй л байна. Гол нь тэдний нэг том төлөөлөгч А.Дыбогийн үзлээр бол Хүннү нь лав түрэг үг биш (тэрээр “этнотим, видимо, не тюркский по происхождению” гэж бичсэн) гэнэ. Тэгэхээр монгол хэлэнд суурилж Хүннү гэдэг угсаатны нэрийг тайлбарлаж болохоор байгаа юм. Анхнаасаа ийм байх ёстой байсан эсэхийг эрдэмтэд эргэн харж хэлэлцэх нь дамжиггүй ч тэдний хувьд маргаан дуусахгүй үргэлжлэх нь ойлгомжтой. Жишээ нь, түүний (ө.х. хүннү гэдэг үгийн) утга хийгээд угсаатны хамаадал тодорхой бус, ямар ч тохиолдолд яагаад ч алтай хэлтэн биш гэдэг нь л тодорхой хэмээн үл үндэсгүй хоосноор тунхаглах явдал байсаар байгаа.¹⁴

Сурвалж бичгүүдэд Хүннү хэмээхийн утгыг заасан тэмдэглэл байхгүй ч гэсэн эрдэмтэн нар Хүннү гэдэг угсаатны нэр ямар утгатай, аль хэлний үг болохыг тогтоох гэж их судалсан. Тэдний судалгааг¹⁵ нэг бүрчлэн тоочих боломжгүй ч

¹² “In spite of the fact that Shiratori and Pelliot were inclined to see a Proto-Mongol element in the language of the Hsiung-nu ...”

¹³ Бартольд В.В. История тюркско-монгольских народов – Академик В.В.Бартольд. *Сочинения*. Том V. Работы по истории и филологии тюркских и монгольских народов. М., Издательство «Наука», ГРВЛ., 1968; Samolin W. Hsiung-nu, Hun, Turk – CAJ. Vol. III, Nr. 2, 1957, pp. 143-150

¹⁴ Дыбо А.В. *Лингвистические контакты ранних тюрков. Лексический фонд: пратюркский период*. Российская акад. наук, Ин-т языкознания. Москва, Вост. лит., 2007; Golden P.B. An Introduction to the History of the Turkic Peoples. Ethnogenesis and State-Formation in Medieval and Early Modern Eurasia and the Middle East. OH., Wiesbaden, 1992

¹⁵ XIX-XX зууны зарим судалгааг Г.Мэнэсийн Угсаатан судлалын 2004 оны дугаарт хэвлэсэн өгүүллээс харж болно. Тэрбээр, Хүннү нэрийн судалгааны тоймыг өгүүлээд “Хүннү нэрийн

ямар санал хэлж, дэвшүүлснийг юуны өмнө нь товчилж ойлгож авах хэрэгтэй. Иймээс судлаачид түлхүү эшилж, дурддаг, мөн хамгийн сүүл үед хийгдсэн судалгаанаас толилуулж байна.

Монголын эрдэмтэн Г.Сүхбаатар “түүхийн сурвалж бичигт «хүннү» хэмээх нь чухам тийм утгатай үг гэсэн тэмдэглэл байхгүй. Нанхиад сурвалж бичигт *хүннү* нарыг нэрлэж заншсан нэр орчин үеийн дуудлагаар «сюнну» [юм], тэмдэглэсэн дүрс бичгийн утгаар *хэрцгий боол* гэсэн үг ... эртний *хятадууд* уг нэрийг тэмдэглэхдээ доромжлох утга бүхий дүрс бичгээр зориуд бичсэн нь тодорхой”¹⁶ гэж өгүүлсэн.

Хо᠋ᠪᠣᠢ, О᠋ᠪᠣᠢ, Hunni, Нū᠋ᠨᠠ гэсэн нэртэй Хүннү хэмээх угсаатны нэр огт хамаагүй, холбоогүй гэж үзсэн Г.Халоун язгуур дуудлагыг нь *xbrōn-no гэж сэргээгээд, м.э.ө. 190-180 онд Тарим-д довтолсон Деметрийн (Demetrios) тухай өгүүлсэн Аполлодорын мэдээн дэх Фр᠋ᠪᠣᠢ, Фро᠋ᠪᠣᠢ-той нэг хэмээхдээ “бараг л тохирч байна, минийхээр маргаангүй” гэж хэлсэн. Эдвин Ж.Пуллиблэнк нь, эхний үе 𐰽 M. hiong бол түвэдийн brañ-тай холбогдох магадлалтайг тэмдэглэе, энэ нь *хун*-ий эхний гийгүүлэгчийг *fl- гэж сэргээх ёстойг зааж байна, 𐰽奴 M. hioŋ-pou < *flōŋ-nañ сэргээлт зөв болохыг, Хүннү ба Фр᠋ᠪᠣᠢ нэг нэр гэж адилтгадаг явдал баталж байна хэмээн 1962 онд бичсэн. Түүнчлэн Г.Халоуны үгүйсгэсэн Хүннү ба Хо᠋ᠪᠣᠢ, О᠋ᠪᠣᠢ, Hunni, Нū᠋ᠨᠠ нэрсийн холбоосыг, Э.Ж.Пуллиблэнк байж болно гэж үзсэн.¹⁷

Товчхондоо, тэд Хүннү (*xbrōn-no, *flōŋ-nañ)-г Фр᠋ᠪᠣᠢ, Фро᠋ᠪᠣᠢ-той адилтгаж, нэг гэжээ.

Артемитын Аполлодор (м.э.ө. 130-87 орчим)-ын мэдээг үндэслэн Евтимед, түүний хүү Деметрий хааны үед *бактричууд* олон ч аймаг эзэлсэн гэж Страбон (м.э.ө. 64/63 – м.э. 23/24) өөрийн «Газар зүй, XI. XI. 1»-дээ бичээд, үүнээс гадна бактрийн хаад газар нутгаа Серов (Σηρων) болон Фринун/Фаунун (Φρουων/Φαυων)-ы нутаг хүртэл тэлсэн гэж нэмж дурджээ. Страбоны эшилсэн мэдээ бол м.э.ө. 100 оны орчим дуусгасан Парфяны түүхийг өгүүлэх «Парфика» гэдэг зохиолдоо Аполлодорын бичиж үлдээсэн баримт юм. Харин *бактричууд* Фрин/Фруной-н талаар олж мэдсэн эсвэл сонссон нь м.э.ө. 100 оноос цааш, Г.Халоуны таамагласнаар бол м.э.ө. 190-180 оны үед ажээ. М.э. 77 онд бичиж дуусгасан «Байгалийн түүх»-дээ Гай Плиний зүүнээс баруун тийш гэсэн дарааллаар овог, аймгийн нэрийг дурдахдаа, эхлээд *сер* (seres), дараа нь *фун* (thuni), *тохар* (focari) тэгээд *касири* (энэтхэг) гэж дараалуулж тэмдэглэжээ. Тэгвэл 125 онд дуусгасан

дуудлагыг баримжаалан утгыг тааварлан тайлбарласан эдгээр сэргээлтүүдийг одоогийн байдлаар үгүйсгэхэд ч бэрхшээлтэй байна, мөн хүлээн зөвшөөрөхөд хэцүү болжээ. ... Энэхүү ээдрээтэй асуудлын үнэн хувийг олж зөв шийдэхийн тулд хэл шинжлэлийн шинэ сэргэг мэдээ баримт, эх хэрэглэгдэхүүнийг нэмэн нягтлах нь онц чухал гэж үзлээ” гэж дүгнэсэн байдаг. (Мэнэс Г. Хүннү хэмээх нэрийн эртний дуудлага ба түүний утга учрын тухай асуудалд: эрдэмтдийн үзэл саналыг эргэн харахуй – Г.Мэнэс. Монгол судлалын өгүүлэлүүд. Эрхилэн нийтлүүлсэн У.Эрдэнэбат, Ч.Амартүвшин, Ц.Төрбат, Ц.Баттулга. УБ., “Мөнхийн үсэг”, 2015, т. 250-254)

¹⁶ Сүхбаатар Г. *Сяньби*. УБ., 1971, т. 95

¹⁷ Haloun G. Zur Üe-tʃi-Frage – ZDMG. NF. Bd. 16 (Bd. 91), Leipzig, 1937, S. 243-318; Pulleyblank E.G. The Consonantal System of Old Chinese. Part I. – Asia Major. NS. Vol. IX, 1962, pp. 58-144

гэж үздэг зохиолдоо Дионисий Периетет энэ нууцлаг *фрин/фруни* нарын тухай өгүүлэхдээ *тохарууд, фрунууд* болон бүдүүлгүүдийн *сер* түмэн (τόχαροι, φροῦνοί, σηροίτε; tochari, phruni, serum) гэж баруунаас зүүн тийш нь дурдаж тоочсон байдаг.¹⁸

Сер/Серика-г эртний Хятад гэдэг, *тохарыг* – *куча* ба *агничууд* (эсвэл юэчжи) гэвэл тэдний дунд байрлаж Фаун, Фрун, Фун гэж хэдэн хувилбараар нэрлэгдсэн ард түмэн нь Хүннү ч байж болох юм. Гэхдээ Тохар (юэчжи) нь Бактри (Дася) улсын хойно нүүж очсон, Серика нь Дорнод Туркестан буюу Серинда мөн гэдэг онолоор бол энэ Фуни нь Дорнод Туркестан, Дундад Азийн заагаар оршиж байсан ард түмэн байх. Заавал нягтлах ёстой асуудал гэдэг нь л одоогоор тодорхой байна. Түүнчлэн эхний хувилбар бодит байдлыг тусгасан нь үнэн бол Хүннү гэдэг нэр хэрхэн ийн Фун/Фруни/Фрини болж хувирсан учрыг тодруулж гаргаж ирэх шаардлагатай.

С.Е.Яхонтов, хүннү 匈奴-гийн дуудлагыг сэргээснээ Г.Сүхбаатарт “1971 оны хоёрдугаар сард ... найрсагаар” өгчээ. Б.Карлгрений *хиунг-но-тай *хуна-г харьцуулсан Г.Сүхбаатар “«сюнну» гэдгийн эртний дуудлага нь үнэхээр иймэрхүү [ө.х. *хун] байх ёстой ... «сюнну» [*хун] гэдгийг «хүн» (кун) гэсэн үг гэж үзэх нь онолын хувьд ч үндэстэй” гэжээ. Эрт балар цагт “«хүн» гэх утгатай угсаатны нэр дэлхий дахинаа нилээд түгээмэл” тархаж, өргөн хэрэглэгдэж байсан гэдэг хандлагын үүднээс Хүннү гэдэг нэрийг тайлбарлаж байсан жишээг Г.Сүхбаатарын бичсэнээр төлөөлөл болгож толилууллаа.¹⁹

Ийм онол баримтлагчдын үзэлд нэг дутагдал байна, учир нь «хүннү» нь хоёр утга үсгээс бүрдэж байна. Гэтэл сэргээлт нь хэт хялбарчилсан байдалтай харагдаж байгааг уншигчид анзаарах буй заа, чухам *huna/*хуна гэх нь хэт энгийн биш биз гэж харагдаж байна.

Яг ийм *хуна эсвэл түүнтэй төстэй сэргээлтэд, Нанай-вандак гэдэг согд/ху угсааны худалдаачнаас Согдын Самаркандад суугч Нанайдвар-т Чирдсвāн (Cīr-δswān/Цзюцюань)-ы эзний арван гуравдугаар он, согдын тооллын *тохмич* (tym’yc/taymīč) сард (313.6.6-7.5) илгээсэн захидалд: эхлээд Чинастан (Cīnastan) буюу Жинь (265-316) улсын нийслэл Сараг (Saray/Лоян) хотыг довтолж эзлээд, дараа нь Кумдан (Khumdān/Чанань), Е (*Ngar^a), Найнайч (N’up’usch) гэсэн бусад том хотыг уулгалан довтолсон хwn/hūn гэх нэрийг дурдсан явдал тодорхой хэмжээгээр нөлөөлдөг юм биш биз гэсэн бодол төрдөг. Хүннүг авиа бичгийн өөр нэг дурсгалд Нūṇa гэж тэмдэглэсэн баримт бий. Дуньхуаны *юэчжи* Жу Фаху (竺法護, zhufahu) буюу Дхармаракша (Dharma-rakṣa) гэдэг лам 280 оны орчим «Татхагатагарбха-сутра» гэдэг шашны судар орчуулахдаа санскритийн Хуна (Nūṇa) гэхийг хятадын Хүннү гэж оноожээ.²⁰

¹⁸ Страбон. Географикон. XI, 11, 1; Плиний. Байгалийн түүх. VI, 20, 53; Дионисий Периетет. Ойкуменес периегеоис. 752

¹⁹ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 194 зүүлт 1, 196, 197

²⁰ Henning W.B. The Date of the Sogdian Ancient Letters – BSOAS. Vol. XII, pt. 3-4, 1948, pp. 601-615; Lévy S. Notes chinoise sur l’Inde. V. 1905

Эдгээр баримтыг үндэслэж судлаачид Хүннү ба Хун-г нэг гэж үзсэн байх. Тухайлбал, “согдын захидлын” тухай 1948 оны өгүүлэлдээ «Хун/Xwn/Hün»-г В.Хеннинг эргэлзэлгүйгээр «Хүннү» мөн гэж үзсэн бол Г.Сүхбаатар “... «хунн», «хуна», «хион» (хионит) гэх угсаатны нэрс нь «хүннү» (сюнну) гэдэг нэр сунжирсан нь юм гэх бүрэн үндэс байгаа” гэжээ. Гэвч Г.Сүхбаатар *хунн*, *хуна*, *цагаан хунн* (эфталит) болон *хүннүчүүд* нь гурван өөр угсаатан, харин улс төрийн түүхээр холбогдож болох талтай гэж цохон тэмдэглэсэн байдаг.²¹

Дундад эртний (МС.) дуудлагаас *χoŋŋ/*χjoŋŋ гэсэн эртний дуудлагыг гаргасан К.И.Бэквит эрт цагт *s- хувьссаар дундад үеийн эхэнд *χ- болж хувирсан, Хүннү нь Saka, Sak(a)dâ», Sakla, Skla(C)da эсвэл бүр Soydâ, Soyîâ гэсэн нэрийн ч галиг байж мэднэ гэжээ. Хүннүгийн *Хоŋа (*Хоŋai)-гаас буддын хоёр ч судрын Нūŋа (са. 288-308) гаралтай гэж К.П.Этвуд үзсэн. Хоёр сударт дурдах улсын нэрсийг үндэслэж, эл хэсэг м.э.ө. I зуун, эсвэл м.э. I зууны эхэнд Кушан Энэтхэгийг довтлохоос өмнө бичигдсэн гэж Э. де ла Вессьер дүгнэдэг. М.э.ө. 129-128 онд Бактрид байсан Хань улсын элч, туршуул Жан Цянь тэнд Цюний хулсан бэрээ, Шугийн бөс байхыг хараад ямар замаар Бактрид хүрдгийг сураглаж мэджээ. К.Этвуд эдгээрийг үндэслэж Хүннү (*хоŋа[*хоŋai]) нэрийг эхлээд *энэтхэгчүүд* мэдсэн, чухам, Сычуаниас Юньнань, Ассам, Бенгалаар дамжин Умард Энэтхэг гэсэн маршрутаар Хүннү нэр цуурайтсаар санскритийн Нūŋа болсон гэжээ. Сонирхолтой нь тэр, «Согдын хуучин захидал» гэдэг баримтуудад тэмдэглэсэн Хwn (Hün) гэдэг, Хүннү нэрийн, согд хэлний хувилбар энэтхэгийн Нūŋа-аас үүсэлтэй гэж үзсэн.²² Өөрөөр хэлбэл, Хүннү гэдэг нэр Сычуань, Юньнань – Ассам, Бенгал гэсэн худалдааны замаар Энэтхэгт дуудаж, санскрит бичиг сударт Нūŋа гэж тэмдэглэгдээд, цааш тархахдаа согд хэлэнд Хwn (Hün) хэмээн хувирч орсон гэнэ. Тэгэхээр 313 онд, согд худалдаачид захидалдаа *өмнөд хүннү* нарыг өөрсдийн мэддэг, хэрэглэж асан Хwn гэсэн нэрээр цохон зааж бичжээ.

Дашрамд өгүүлэхэд, торгон замаас өмнө, эртний хятадын бараа таваар Энэтхэгээр дамжин Дундад Ази хүрч байсныг В.В.Бартольд 1916 онд хэлж байжээ.²³

Модун шаньюй улс байгуулаад, Онгийн голын эрт цагийн *Хоŋai(Хүннү) гэсэн нэрийг улсын нэр/цол болгож хэрэглэсэн ба Онги гэдэг нэрийн VIII-IX зууны түрэг хувилбар нь *Hoŋi бөгөөд *Хоŋа(i)-тай ойр (clearly approaching) юм²⁴

²¹ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 191

²² Beckwith C.I. *Empires of the Silk Road. A History of Central Eurasia from Bronze Age to the Present*. PUP., Princeton and Oxford, 2009; Atwood C.P. *Huns and Xiōngnú: New Thoughts on an Old Problem – Dubitando: Studies in History and Culture in Honor of Donald Ostrowski*. Edited by Brian J.Boeck, Russel E.Martin, and Daniel Rowland. Slavic Pub., Bloomington, 2012, pp. 27-52; de la Vaissière E. *Huns et Xiongnu – CAJ. Vol. XLIX, No1, 2005, pp. 3-26*; Боровкова Л.А. *Кушанское царство (по древним китайским источникам)*. ИВ РАН, Москва, 2005

²³ Бартольд В.В. *Греко-бактрийское государство и его распространение на северо-восток – В.В.Бартольд. Сочинения. Том II, часть 2. Изд. Наука, М., 1964, стр. 456*

²⁴ Atwood C.P. *The Qai, the Khongai, and the names of the Xiōngnú – International Journal of Eurasian Studies. Vol. II. Beijing, 2015, pp. 35-53*

гэж К.Этвуд хоёрдох өгүүлэлдээ бичсэн одоогоор олж харсан хамгийн сүүлийн судалгаа болно.

Хүннү нэрийн талаарх цөөн судалгааг сонгож толилуулсан тоймоос харвал энд хөндөн буй сэдвийг тухайн цаг үедээ урагш ахиулж шинэ түвшинд хүргэсэн ч зарим нь учир дутагдалтай санал болжээ, гэхдээ өнөөдрийн өндөрлөгөөс харахад ийм байна гэдгийг мартаж болохгүй.

Тухайлбал, грек-ромын сурвалжууд дахь Фруни, Фуни, Фаун гэдэг нэр Хүннүтэй холбогдох найдвартай баримт хараахан алга. Бас яаж ингэж хувирсан нь ч тодорхойгүй бүрхэг хэвээр байгаа. Согд, Сак гэсэн нэртэй холбоотой гэх сэжүүр бүр ч найдвар муутай таамаг бололтой. Учир нь *сogд*, *хүннү* гэсэн хоёр угсаатан нэг нэртэй байсан юм бол яагаад *сogдууд* хожим нэр нэгтэй асан ахан дүүсээ Хун гэж нэрлэв гэдэг асуулт урган гарч ирнэ.

Хүннү (м.э.ө. 311 он орчим) нь Хуна (*hūna* – 280 он; *xwn~hūn* – 313 он)-тай холбоотойд эргэлздэг судлаачид бий.²⁵ Тэд *сак*, *сogд* зэрэг иран хэлтнүүд Хуна нэрээр нүүдэлчдийг ерөнхийд нь нэрлэдэг, хам нэр гэсэн үндэслэл гаргасан. Тэгэхээр асуудал шийдэгдээгүй, нээлттэй сэдэв гэж үзэж болох ба бидний хувьд одоогоор тодорхой хэлэх санал алга, гэхдээ Хүннү нэрийн дор, *жинхэнэ хүннү* нарт захирагдаж байсан *псевдохүннү*-чүүдийн заримынх нь угсаатны нэрийн судалгаа тухайн асуултад хариулах боломж нээнэ гэж хувийн зүгээс үздэг. Мөн Жу Фаху, Нанай-вандак нарын тэмдэглэсэн нь Хүннү гэдэг нэр хятад сурвалжид тэмдэглэгдсэнээс хойш зургаан зуугаад жилийн дараах үзэгдэл ба тэр цагт *хятад бус харийнхан* (*non chinese*) Хүннү хэмээх угсаатны нэрийг өөрсдийн хэлнээ тэмдэглэх зүй тогтолтой болчихсон гэж бас үзэж болох юм.

Хүннү нэрийн тухай К.Этвудын хоёр ажил сонирхолтой ч, харамсалтай нь түүхэн баримттай эрс зөрж байна. *Нэгд*, Онгийн гол *хүннүд* үнэхээр чухал эрхэм шүтээн байсан гэх баримт байхгүй, *хоёрт*, Онгийн гол *жинхэнэ хүннүчүүдийн* түүхийнх нь эхэн үеийн нутаг дэвсгэрт хамаарч байсан эсэхийг найдвартай судалсан судалгаа одоогоор алга, м.э.ө. V/IV зуунаас хойших Хүннүгийн нутагт дэвсгэрт ч багтаж байсан эсэх нь тодорхойгүй бөлгөө. *Гуравт*, Хүннү нэр хятад сурвалжид Модунаас зуу илүү жилийн өмнө тэмдэглэгдсэн, энэ нь хятад түүхчдийн *солилт*, *оруулга ажиллагаа* биш, *дөрөвт*, Модун улсаа байгуулаад “тийн нэрлэв” гэх сэжүүр олгохуйц баримт хараахан олдоогүй, гэтэл хожмын хятад сурвалжаас үзвэл – умардын тийм овог, аймаг, түүхэн бие хүн улс гэр байгуулаад ингэж нэрлэв гэж цаг тухай бүрд нь тэмдэглэдэг тохиолдлууд цөөн бус. *Тавд*, *ордосын соёлтнууд*, *гурван хугийхан* умард руу нүүж ирээд нутгийнхантай холилдож *хүннүчүүдийн* угсаа гарвальд онцгой үүрэг гүйцэтгэсэн гэдэг онол сүүл үеийн судалгаагаар батлагдахаас илүү няцаагдаж эхэлсэн билээ. Харин манай археологичдын нэг хэсэг нь одоо болтол уул онолд гүн итгэсэн хэвээр байгаа нь харамсалтай.

²⁵ Г.Халоун (1937), О.Мэнчен-Хелфен (1944/1945) нар ингэж үздэг.

Эрдэмтдийн²⁶ судалгааг тоймлож дурдахдаа, холбогдуулж хэлснээ товчилж, нэгтгэн толилуулья.

нэг, Хүннү нэрийг түрэг хэлний үүднээс тайлбарлах боломжгүйг А.Дыбо цохон тэмдэглэжээ.

хоёр, Хүннү нэр алдаршиж, тархахдаа эхлээд Энэтхэгт Нїңа гэж тэмдэглэгдээд цааш түгжээ. Нэг нь согдын Хwп/Нїп юм, *согдууд* эртний Хятадад ирэхдээ Хуна гэсэн нэрийг мэддэг, ашиглаж байсан хэмээх К.Этвудын хоёр санал бараг л ‘байгаа оночихжээ’.

гурав, Хүннү-г «хүн» гэж сэргээх нь хамгийн үнэмшил муутай таамаглал. *дөрөв*, грек-ром сурвалжийн Фуни (Φαυνοι) зэрэг нэрстэй Хүннү холбоотойг нягтлууштай. Зарим судлаачийн бичсэнчлэн *x-* нь *φ-* болж шилжих нь зүй тогтолт үзэгдэл²⁷ гэдгийг анхаарвал Фуни (φαυνοι) нь Хүннү гэх нэртэй холбогдох магадлал нэмэгдэж байна.

тав, Хүннү, Сак, Согд гэх нэрсийн холбоос хамгийн эргэлзээтэй саналын нэг болжээ.

зургаа, Онги ([X]онг) голын нэрээс үүссэн гэх саналыг дахиж нягталмаар.

Хүннү нэрийн талаар эрдэмтдийн дэвшүүлсэн санал, онолд дээрх шиг эргэлзээтэй, үндэслэлгүй, учир дутагдалтай зүйлс бий ч асуудлыг нэг тийш болгосон гэж үзмээр, дэмжиж зөвшөөрөх зүйлс бас байгааг тэмдэглэе. Үүнд, м.э.ө. 311 оны орчим утга үсгээр галигласан тус нэр м.э.ө. 129 оноос өмнө Шу-Ба/Сычуань нутгаар дамжин Энхэтхэг хүрсэн (К.Этвудийн санал) нь Хүннү хэмээх нэрийн тархалтын өмнөд чиглэл юм байна. Үүнээс гадна өрнө зүгт Дорнод Туркестанаар дамжин Грек-Бактри хүрчээ. Митритад хааны (124/123-91/88) үед Парфян улсад сууж байсан Артемитийн Аполлодор «Парфика» (са. м.э.ө. 100/91) гэдэг зохиолдоо *бактри* хаад газар нутгаа *сер*, *фрин* нарын хязгаар хүртэл тэлсэн гэж тэмдэглэснийг Страбон дурдсан нь ингэж үзэх (Г.Халоун, Э.Пуллиблэнк) үндэс болсон ба м.э.ө. 190-180 оны түүхэн үйл явдал гэж Г.Халоун тайлбарлажээ, дахиж харууштай сонирхолтой санал.

Базаад хэлбэл, үнэхээр эрдэмтдийн хэлсэнчлэн байсан гэж төсөөлбөл, санскритийн Нїңа (са. м.э.ө. 215-129), грекийн Φρῦνοι²⁸ (са. 215-180) гэх хоёр нэрийн нэг нь, Хүннү гэсэн нэрийн – утга үсгийн дуудлагаарх хэлбэр цааш тархаж, нөгөө нь Дорнод Туркестанд байсан хэлний дуудлагаар дамжин бараг нэг л цаг үед тэмдэглэгдсэн тэмдэглэгээ байх боломжтой гэсэн үг.

²⁶ Г.Халоун, Э.Ж.Пуллиблэнк, С.Е.Яхонтов, Г.Сүхбаатар, А.В.Дыбо, К.И.Бэквит, К.П.Этвуд нар.

²⁷ Иностранцев К. Хунны и гунны. Второе дополненное издание. – *Труды туркологического семинария ЛИЖВЯ*. Том I. Л., 1926, стр. 74

²⁸ Φρῦνοι, Φρῦνον, Φαυῶν гэх зэрэг олон хувилбарыг судалсан К.Немети анхны уугал хэлбэр нь *φαυνοι* байх гэж үзсэн (Зуев Ю.А. К этнической истории усуней – ТИИАЭ АНКазССР. Том 8. А-А., 1960, стр. 19).



II. Хүннү хэмээх угсаатны нэрийг утга үсгийн сурвалжид м.э.ө. IV зууны сүүлээр тэмдэглэжээ.²⁹ Сурвалжид үзэгдсэн он цагийг дурдах учир нь угсаатны нэрийн судалгааны онцлогоос шалтгаалж байгаа юм. Эрдэмтдийн өгүүлэхээр бол угсаатны нэрийн гарал үүслийг тайлбарлах, түүний утгыг олоход юун түүрүүнд түүний [ө.х. угсаатны нэр] өртсөн хожмын бүх өөрчлөлтийг арилгаж, анхдагч хэлбэрийг тогтоох явдал хамгийн чухал байдаг гэнэ. Түүнчлэн, зөвхөн нэг хэлний хөгжлийн явцын хүрээнд хамрагдаж байсан ч гэсэн угсаатны нэрийн хэлбэр, дуудлага заавалчгүй өөрчлөгдөж хувьссан байдаг ба нэг хэлнээс нөгөө хэлэнд тэмдэглэх явцад бүр их өөрчлөлт, гажилтанд өртдөг, ялангуяа ихээр хамгийн өртөмтгий нь *авиа* гэдгийг судлаачид хэдийнээ тогтоожээ.³⁰

Энэ л шалтгааны улмаас Хүннү гэх үгийг, галигийг хэзээ анх тэмдэглэгдсэн нь цаашдын судалгаанд их чухал үүрэгтэй нь харагдах байх. Тэгэхлээр энэ галигт хэрэглэсэн хоёр утга үсгийн эртний дуудлагыг Хань (м.э.ө. 202 - м.э. 8) ба Цинь (м.э.ө. 221-206) улсаас цааших үед холбогдох дуудлагыг үндэслэж, өөрөөр хэлбэл Хань улсын үеийн дуудлага сэргээлт биш харин түүнээс арай урагш үеийн сэргээлтэд тулгуурлах ёстой.

Орчин цагийн эрдэмтдийн судалгаанд тулгуурласан дуудлагыг толилуулахын урьд, өмнөх үеийн судлаачдын хэвлэж нийтэлсэн сэргээлтийн заримаас түүвэрлэж толилуулъя.

Халоун, 1937	*xbrōn-no (Аполлодорын түүхэнд тэмдэглэсэн Фрῶνοι/Фроῦνοι)
Пуллиблэнк, 1962	*fḷōn-naḥ (Фроῦνοι гэдэг нь бараг маргаангүй гэсэн Халоуныг эшилсэн)
Яхонтов, 1971	*хуна
Пуллиблэнк, 1986	*hwənh-ná (Фрῶνοι/Φαῦνοι/Phrynoi-тай харьцуулж болно)

²⁹ М.э.ө. 311 он.

³⁰ Никонов В.А. *Этнонимия – Этнонимы*. Ответственный редактор В.А.Никонов. М., 1970, стр. 30, 28

Дыбо, 2007	*᠓᠔᠓-nhā = hunga (этноним, видимо не тюркский по происхождению)
Бэквит, 2009	*ᠬᠣ᠓ᠨᠮ ~ *ᠬᠣ᠓ᠨᠮ (saka/sak(a)dâ, sakla/skla(C)da, soᠮdâ/soᠮlâ)
Этвуд, 2012/2015	*хо᠓а ~ *хо᠓ai (Онги (8 th cen. tü. Но᠓i) голын нэрээс үүссэн)

Хүннү гэдэг галигийн м.э.ө. III зууны өмнөх үеийн дуудлага *ho᠓-nâ³¹, *q^hᠣ᠓-n^ʰa³² гэж сэргээгдэж байна.

Хүннү галигийн сэргээлтэнд үндэслэж язгуур дуудлагыг 2007-2015 онд *хунга* *᠓᠔᠓-nhā³³; *хона/хуна* *hona/*huna³⁴; *хонгай* *хо᠓ai³⁵ гэж эрдэмтэд сэргээснээс үзвэл *-нү/-ни* үеийг *-а, -ай* байжээ хэмээжээ, арай л хялбар сэргээлт болсон гэж санагддаг.

Гэхдээ, *-нү/-ни*-г хэрхэн сэргээхээс Хүннү нэрийн язгуур дуудлага зөв сэргээгдэх эсэх хамаарна. Харь гаралтай орчуулагчид буддын судрын нэр томьёог хятадаар галиглахдаа нэгээс хоёр, заримдаа гурван ч үеийг нэг утгат үсгээр оноож тэмдэглэж байжээ.³⁶ Иймд Хүннү 匈奴-гийн хоёрдугаар үе 奴 нь өмнөх хүн 匈 гэх үедээ шингэх бус харин ч түүнээс дутахгүй сэргээгдэх үе байсан хэмээн үзсэн юм. М.э.ө. IV зууны төгсгөл үед амьдарч байсан хятад бичгийн хүмүүс *-нү/-ни*-гээр харийн ямар ямар авиа-үсгийг галигласныг нэхэн авч үзэхэд *-нү*-г *nâ болон *n^ʰa гэсэн сэргээлт хангалтгүй. Гэвч чухам, энэ л *-на* (*nâ ба *n^ʰa)-д хамаг нууц нуугдаж байсан юм билээ.

Харин, *нү/-ни*-гийн учрыг ойлгож тайлахад У.Бакстер, Л.Сагар нарын хамгийн сүүл үеийн (2011/2014) судалгаа суурь үндэс болж өгсөн юм. Тэд, *-н* ба *-а* гэсэн хоёр авианы дунд ямар нэг авиа байснаа гээгдсэнийг « ʰ » (*n^ʰa) гэсэн тэмдэглэгээгээр зааж өгсөн гэж бид ойлгоод, энд л гол сэжүүр, гогцоо байжээ гэж үзсэн билээ. Үүнийг маань өөр нэг эртний хятад авиа сэргээгч А.Шюслерийн хэвлүүлсэн бүтээл дэх сэргээлт улам “хөгжөөсөн” юм. А.Шюслер *-нү* (奴, ní) утга үсгийн гол бүрдэл, язгуур нэгтэй нэгэн утга үсэг(女, nǚ)-ийн эртний дуудлагыг сэргээхдээ *n-* авианы ард *-r* авиа байсан гэж сэргээгээд тус үсгийг бүхэлд нь *nra? гэж үзсэн билээ.

³¹ Schuessler A. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia*. UHP, Honolulu, 2009, 12-5, 1-56

³² Baxter, W. and L. Sagart. *Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00)*. 2011, pp. 146, 95

³³ А.В.Дыбо, 2007 – Дыбо А.В. *Лингвистические контакты ранних тюрков. Лексический фонд: пратюркский период*. Российская акад. наук, Ин-т языкознания. Москва, Вост. лит., 2007, стр. 103

³⁴ Schuessler A. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia*. UHP, Honolulu, 2009, p. 209

³⁵ Atwood C.P. The Qai, the Khongai, and the names of the Xiōngnú – *International Journal of Eurasian Studies*. Vol. II. Beijing, 2015, pp. 35-53

³⁶ Жишээ нь – фу, 佛, fu EH. *bjət = Skt. buddha; жи, 紙, zhi EH. *tʃjei/gjie = Skt. jetavana; шэвэй, 舍衛, shewei EH. *ʃja-ɣjwat = Skt. śrāvastī; фань, 梵, EH. *(r)jam = Skt. brahmā гэх мэт (Coblin, South W. *A Handbook of Eastern Han Sound Glosses*. CUP, Hongkong, 1983, p. 241).

Ингээд энэ гурван судлаачийн ажлыг нэгтгэж хараад – бид учрыг нь олохгүй мунгинаад, арван хэдэн жил тэр дороо эргэлдэж байсан маань үгүй болж, урагшлах гарц нээгдсэн юм. Өөрөөр хэлбэл, энэхүү *-ну* үеийг **-на*-гаас гадна бас **na* → **n'a* + **nra?* = **nra?* байж болох юм байна гэсэн таамаглалд бид хүрсэн юм. Нөгөө арван хэдэн жилийн маань гацаа ингэж арилсан билээ. Байдал үнэхээр, найдаж байгаа шиг минь байх аваас, нэг ёсны А.Шюсслер (2009), У.Бакстер, Л.Сагар (2011/2014) нарын сэргээлтгүйг бага зэрэг хувиргахад *нэг* – **hoŋ-nra?*, *хоёр* – **q^hoŋ-nra?* гэсэн сэргээлттэй болсон ажээ. Чухам, Хүннү гэдэг үг/галиг/нэрийн хоёрдугаар үеийг арай өөр өнцгөөс харж хамтад нь авч үзвээс бидний өмнө – *hwənh-ná*, *ᠬᠣᠨ-nhā*, *hoŋ-nā*, *ᠬᠣᠩᠨᠠ*, *ᠬᠣᠩᠨᠠ*, *hoŋ-NA* гэсэн сэргээлт биш харин **hoŋ-nra?* / **q^hoŋ-nra?* гэсэн тэс өөр хэлбэртэй сэргээлт гарч ирсэн юм.

Эл сэргээлтээс бас ямар үг байсан бэ? гэдэг нь шууд харагдахгүй. Иймд арай хожмын боловч *хүннүчүүдээс* асар холдоогүй сурвалжнаа тэмдэглэсэн угсаатны нэр дундаас хайх арга зүй баримталж, «Монголын нууц товчоон», «Судрын чуулган»-ыг хайлтын талбараа болгосон. Хүннү хэмээх нэрийн “шинэ” сэргээлтээс нэлээд олон жилийн өмнө, бид нарын анхаарлыг 1228/1240, 1307/1311 онд бичсэн монголын хоёр их хөлгөн судар дахь «хон³⁷» гэх үг орсон нэрс татаж байсан билээ. Ялангуяа, «Хонгирад» (SHM. <q>onggirad/<q>onggirat³⁸; СЛ. кункрāt/кунгират³⁹; СС. qunqirat⁴⁰; И.Н.Березин, кункрāt) нэр үнэхээр анхаарал татаж байсан бөгөөд харин – «**hoŋ-nra?*, **q^hoŋ-nra?*» гэсэн сэргээлттэй болсноор⁴¹ таамаглал маань нэг алхам урагшилж, чухам Хүннү гэдэг нэр монгол сурвалжуудын (q)onggirad, (q)onggirat бололтой гэх үзэл таамаглалд маань саад байхгүй болсон гэж бид үзсэн билээ.⁴²

Санаагаа товчилж илэрхийлбэл:

Угсаатны нэр тэмдэглэсэн *хун-ну*, 匈奴, *xiōng-nú* гэдэг хоёр утга үсгийн Цинь/Хань улсын өмнөх үеийн дуудлага нь **hoŋ-nā* < **hoŋnra?* эсвэл **q^hoŋ-n'a* < **q^hoŋnga* юм байна. Чухам **hoŋ.nra<d>/*hoŋ.nra<t>* → **hoŋra<d>/*hoŋra<t>* (Шюсслер) эсвэл **q^hoŋ.nra<d>/*q^hoŋ.nra<t>* → **q^hoŋra<d>/*q^hoŋra<t>* (Бакстер, Сагар) гэж сэргээгдэнэ. Энэ нь **qoŋyra<d/t>* ~ **qoŋyra<d/t>* ~ **qoŋgra<d/t>* гэсэн хүннү (монгол) үгийн галиг юм байна.

³⁷ 2010 онд Түүхийн судлалд хэвлэсэн өгүүлэлдээ «Хон» гэх үгийн талаар дурдсан. (Батсүрэн Б. Хүннү, Тоба нэрийн тухай санал – *Studia Historica*. Tom. XL. Fasc. 2. УБ., 2010, т. 41-57)

³⁸ de Rachewiltz I. *Index to the Secret History of the Mongols*. Part II: Index. IU., Bloomington, p. 280

³⁹ Рашид-ад-дин. *Сборник летописей*. Том I книга первая. Перевод с персидского Л.А.Хетагурова, редакция и примечания А.А.Семенова. М-Л., 1952, стр. 75 прим. 1, 78, 160 г.м.

⁴⁰ Rashiduddin Fazlullah's. *Jami' u't-tawarikh: Compendium of Chronicles*. A History of the Mongols. Part One. English Translation & Annotation by W.M.Thackston. Harvard University, 1998, pp. 24, 26, 84 г.м.

⁴¹ Сэргээлтгүйн эл хувилбарыг олоод бас хэдэн жил болжээ, энэ хооронд бид чадлын хэрээр өөрсдийн хувилбарыг шалгамаар аядаж, эрэл хайгуул хийсэн, хийсээр ч байх болно. Үүнд, Жэнжан Шанфаны судалгаа (2003/2019), Саус Коблины Зүүн Хань улсын үеийн дуудлага сэргээсэн толь, Бакстер, Сагар нарын 2014 оны зохиол зэрэг судалгаат толиуд, нэг сэдэвт бүтээл багтана.

⁴² Яагаад “үзсэн билээ” хэмээн бичсэн гэхээр, Хүннү бол Хонгирад гэсэн үгийн галиг юм байна гэсэн энэ үзлээ, бичээд бас хэдэн жил болчихсон Хүннүгийн талаарх номынхоо нэг зүйл болгосноо ийн хэлсэн хэрэг. Түүхэн газар зүй, нийгмийн байгуулалттай холбоотой нэг хоёр гурван зүйлээс бусдыг нь бичээд бэлдчихсэн байгаа.

Тус санал маань өчүүхэн боловч бодит байдалд дөхөж чадсан бол бид Хүннү гэж бичиж байгаа Xiongnu гэсэн угсаатны нэр бол гадаадын эрдэмтдийн хэлж ярьж байсан шиг – *хуна*, *хунга*, *хонгай* бус харин аман түүхийн мэдээгээр долоон зуун наяд онд Эргүнэ кунаас *хиад*, *урианхайн* хамт гарч ирсэн⁴³, дундад эртний монголын *хонграт* ~ *хонгирад* гэдэг дотроо бас олон салбартай угсааулс төрийн томоохон бүлэг/нэгжийн нэр байжээ гэсэн цоо шинэ, өмнөх санал, таамаглалуудаас зарчмын эрс ялгаатай онол/санал дэвшүүлж байна.

Монголын дундад эртний үеэс хойших түүхэнд *хонгирадуудын* гүйцэтгэсэн үүргийг ялангуяа эзэнт гүрний үеийн *хонгирадынхны*, өөрөөр хэлбэл их хаадын хатад ба нагац нарын гүйцэтгэсэн үүргийг монголын түүхчид, гадаадын эрдэмтэд тун сайн мэдэх бөлгөө. Оргүй хоосон зүйл дээр үүсээгүй түүхт нөхцөл байдал гэдэг нь бидний нэр сэргээж оноосон оролдлогоос харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хүннүгийн үеийн *хүннү*(люаньти/сюйляньти) – *хуянь*, дундад зууны *хиад/боржигин/алтан ураг* – *хонгирад/олхунуд/ихирэс/горлос* гэсэн улс төр-ураг садны холбоо багаар бодоход мянга илүү жил үргэлжилсэн тогтвортой тогтолцоо байсан гэж үзэх саналтай байна.

Монголын гурван гол сурвалжийн нэг «Судрын чуулган»-аас л түүвэрлэхэд *хонгират/хонграт*-аас гадна *хон/хун (кон/кун)* гэсэн язгууртай *дарлигин/нируны* – 1) хонхлаут, кункулают, қўнкалаўт, qongli'ut, 2) хонхотан, qonqotan, 3) хунжин (кунжин?); *хонгиратын* – 4) хунглиют, кунклиут, qongli'ut; *жалаирын* – 5) кунксаут, қунгқаўт, qongqa'ut; *хэрэйдийн* – 6) конкаит (донгайд) гэсэн зургаан овог, аймгийн нэр тодорно.⁴⁴ Үүнээс гадна «Монголын нууц товчоон»-ы 187-р зүйлд хэрэйдийн Ван ханы шууд захиргааны Онхожид/Ongqojit гэдэг овгийн нэрийг дурддаг. Онги голын нэрийг эрт цагт VIII-IX зуунд *Hoŋi харин хүннүгийн цагт *Хоŋa(i)-тай ойролцоо хэлбэртэй байсан гэдэг К.Этвудын санал дагуу авч үзвэл Онхойит ~ Онхожит гэдэг нэр *Хонхойит/Хонхожит байх боломжтой мэт. Г.Сүхбаатар нарын судлаачдаас Онгуд гэж сэргээдэг вэньюйди 濛兀 禺鞮 аймгийн нэр ч бас *х- -тэй сэргээгдэнэ, учир нь хятадын эрдэмтэн Жэнжан Шанфаны сэргээлтийн системээр Вэньюйдийн ОС. *qun-ŋo-tee⁴⁵ < *qon.ŋu.t болох юм. Тэгэх аваас жаран тав, зургаан овог, аймгаас *хамаг монгол-хэрэйд-онгуд* нийлсэн долоо-наймынх нь угсаатны нэр «хон, хун» (кон/кун)-оор эхэлж байна, барагцаагаар угсаатны нэрийн арван хувь нь гэсэн үг. Хамаг монголын – *дарлигин, нирун* болон *жалаир* тэр бүү хэл Хэрэйдэд «хон» язгуурт овог байгаа

⁴³ Рашид-ад-дин. *Сборник летописей*. Том I книга первая. Перевод с персидского Л.А.Хетагурова, редакция и примечания А.А.Семенова. М-Л., 1952, стр. 154; Rashiduddin Fazlullah's. *Jami'u'l-tawarikh: Compendium of Chronicles. A History of the Mongols. Part One. English Translation & Annotation by W.M.Thackston. Harvard University, 1998, pp. 80-81*

⁴⁴ Рашид-ад-дин. *Сборник летописей*. Том I книга первая. Перевод с персидского Л.А.Хетагурова, редакция и примечания А.А.Семенова. М-Л., 1952, стр. 78, 93, 98, 128, 160-164, 166-168, 197; Rashiduddin Fazlullah's. *Jami'u'l-tawarikh: Compendium of Chronicles. A History of the Mongols. Part One. English Translation & Annotation by W.M.Thackston. Harvard University, 1998, pp. 26, 37, 84-86, 87, 89-90*

⁴⁵ Жэнжан Шанфан. Шангу иньси. Ди-эр-бан. Шанхай Цзяюй-шубан-шэ (郑张尚芳. 上古音系. 第二版. 上海教育出版社) 2019, т. 507, 560, 481

нь, бас Онгудын нэр бүр эрт цагт *⟨q⟩o.ɲi.t байсан нь үнэхээр сонирхол татаж байна. Харнууд, шарнууд, борнууд, цагаанууд гэх мэт бүр эрт цагийн томоохон угсаатны нэгж олширч тархсаар, ураг, овог, цусан төрлийн гэр бүлүүдийн түвшний хам нэр болж монгол угсаатан даяар түгсэн жишээг харгалзан үзвэл *хүннүчүүд* цаг хугацааны уртад олширч энд тэнд тархсаны ул мөр ч байж мэднэ. Юутай ч *хонгират* (хонграт), *конкаит* (донгайд), *хонхаут* (qongqa'ut, қунгқәүт кунксаут), *хонхлаут* (qongli'ut, қүнкалаүт, кункулают), *хонхотан*, *хунглиют* (qongli'ut, кунклиут), *хунжин* (хунжин?) *онгуд* (*⟨q⟩o.ɲi.t) нар *хүннүчүүдтэй* шууд холбоотой байх магадлал их гэж таамаглаад энэ хэсгийг өндөрлөе.

ЛЮАНЬТИ/СЮЙЛЯНЬТИ

XIX зууны өрнөдийн хувьслын онолыг үндэслэгчдийн нэг Ф.Энгельс, овгийн нэр тухайн овгийн эрх дархтай салшгүй холбоотой⁴⁶ гэж хэлсэн байдаг. Үүнийг харгалзан үздэггүй юм аа гэхэд томоохон угсаатны нэгжийн доторх овог, аймгийн нэрийн судалгаа тухайн субъектийн угсаа хамаадлыг тодруулахад дэм болох учиртай санагдана.

Баруун Хань улсын судар түүхэнд Люаньти, Зүүн Хань улсын түүхнээ Хэйляньди буюу Сюйляньти гэж үлдсэн галигийн дуудлагыг – де Гро, Э.Пуллиблэнк, Учралт нар *randee ~ *hirēndee; *vlān-teh̄ ~ *vlōn-teh̄, *hwrān-těj; *līwantiei, kīalīwandie гэж сэргээжээ.⁴⁷

Люаньтийн ЗХ. *r(h)wan-dē/thē дуудлагыг үндэслэн А.Дыбо *runde ~ *rwande гэсэн үгийн галиг, уул үг нь дундад үеийн сак хэлний “хаад” гэх утгатай гэж үзсэн. Хожуу Хань улсын түүх судар дахь Сюйляньти болон түүний *ha-ran-dē гэсэн С.А.Сторостиний сэргээлтийг үндэс болгосон Б.Нацагдорж “Хүннү гүрний хааны овгийн Сюйляньти (хятадаар, 虛連題) бол монголын Хоридай (монголоор, qogidai) юм” гэжээ.⁴⁸

Люаньти ямар үг болох нь мэдэгдэхгүй байна, харин Сюйляньтийн сэргээлтээс эхний үеийг Люаньти-д “нэмж оруулбал” юу болох нь мэдэгдэнэ гэсэн профессор Учралт, тэдгээр үгийг *kīalīwantiei, *kīalīwandie гэж сэргээгээд,

⁴⁶ Ф.Энгельсийн тодорхойлсон уг томъёолол арай өөр, тэнд „омгийн эрх нь ч омгийн нэртэй салшгүй холбоотой“ гэж бий. Энгельс Ф. Эрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл – К.Маркс, Ф.Энгельс. *Түүвэр зохиол*. Боть 3. УБ., 1971, т. 309

⁴⁷ Groot J.J.M. de. Die Hunnen der vorchristlichen Zeit. Chinesische Urkunden zur Geschichte Asiens. Erster Teil. Berlin und Leipzig, Walter de Gruyter & Co., 1921, S. 57; Pulleyblank E.G. The Consonantal System of Old Chinese. Part I. – Asia Major. NS. Vol. IX, 1962, p. 139; Пуллиблэнк Э.Дж. Язык сюнну – Зарубежная тюркология. Вып. I. Древние тюркские языки и литературы. Ответственный редактор акад. А.Н. Кононов. Составитель С.Г. Кляшторный. М., ГРВЛ., 1986, стр. 66-67; Учралт. Хүннү хэлний судлал. Монгол бичгээс буулгасан М.Жавзансүрэн. УБ., “Жиком пресс” ХХК, 2015, т. 219-234

⁴⁸ Дыбо А.В. Лингвистические контакты ранних тюрков. Лексический фонд: пратюркский период. Российская акад. наук, Ин-т языкознания. Москва, Вост. лит., 2007, стр. 108; Нацагдорж Б. mongγol-un niγuᠰ tobᠳiγan как источник по истории протомонголов – БС. II боть, №2(002). УБ., 2009, т. 138-140

хоёрдугаар үеийн эхний гийгүүлэгчийг *r-* -ээр соливол *kīarīwant, *kīarīand гэж уншигдана, хоёрдугаар үеийн төгсгөлийн *-n* гийгүүлэгч бол “монгол хэлний хөдлөх үндсийн авиачилгаа болно. ... Хөдлөх үндэс нь сугарах ёстой тул энэ хоёр авиачилгаанд гарсан *-n* гийгүүлэгчийг хаяж *kīarīwat, *kīarīad гэж унших хэрэгтэй, ... энэ хоёр авиачилгаа «Монголын нууц товчоон» дахь kereit-тэй үндсэндээ тохиролцож байна ... хэрэй, хэрэйн, хэрэйд овогтон бол [Хүннүгийн] чинги (шаньюй)-н овог, аймгийн нэр болно” гэж үзсэн.⁴⁹

Эдгээр сэргээлт, нэрийн тайлал аль аль нь байгаа оноогүй. Э.Пуллиблэнк, хүннүчүүд “кет хэлтэн байсан” гэдэг “алдарт онолдоо автсан” бол А.Дыбо, хүннү нарыг монголчуудаас л холдуулдаг аргаар асуудалд хандаж, илэрхий зүйлсийг төөрүүлж тайлбарлажээ. Профессор Учралт, Б.Нацагдорж нарын Хэрэйд, Хоридай гэсэн тайлал ч эргэлзээтэй, будилсан байна.

Люаньти (攀鞬), Хюйляньти/Сюйляньти (虛連題)-н дуудлага:

		<u>люаньти</u>	<u>сюйляньти</u>
Шюessler, 2009	ЛН.	*lyan-de/te	*hia-lian-de/te
Старостин, 1998	ВХ.		*ha-ran-diē
Пуллиблэнк, 1986	Нан.	*hwràn-téj ⁵⁰	
Старостин, 1998	ЗХ.	*r(h)wan-dē ⁵¹	*ha-ran-dē ⁵²
Жэнжан, 2003	ОС.		*qha/kha-ren-te ⁵³
Шюessler, 2009	ОСМ.	*ron-dê/tê ⁵⁴	*ha-ran-dê/tê ⁵⁵
Бакстер, Сагар, 2011	ОС.		*q ^h a-ran-d ^h e ⁵⁶

Хятад хэлний орчин цагийн *l-* -ийг эрт цагт ихэвчлэн **r-* -ээр дуудаж байсан бололтой.

Хүннү/*q^hoŋ.na(ɬ) гүрний шаньюй/*дарга нар гардаг ургийн нэрийг тэмдэглэсэн 2 үсгийн эхний люань (攀, lián)-тай холбогдуулж нэгэн зүйлийг онцлон тэмдэглэе.

М.э.ө. 177/176 оны Хүннү-Юэчжийн дайны дараа Хүннү-д захирагдаж байгаад сүүлд Хань улсыг дагасан Лоулань (樓蘭/闐, loulan, ОС. *kro-k.rʰan⁵⁷ < *kro-ran = Kṛgān/Крорайна), Ордосын Бор тохойн зүүн бие, одоогийн Шаньси

⁴⁹ Учралт. Хүннү хэлний судлал. Монгол бичгээс буулгасан М.Жавзансүрэн. УБ., “Жиком пресс” ХХК, 2015, т. 219-234, т. 219-234

⁵⁰ Пуллиблэнк Э.Дж. Язык сюнну – Зарубежная тюркология. Вып. I. Древние тюркские языки и литературы. Ответственный редактор акад. А.Н. Кононов. Составитель С.Г. Кляшторный. М., ГРВЛ., 1986, стр. 66-67

⁵¹ Китайские иероглифы. Составитель Старостин С. А. Цахим пдф, стр. 1802, 1689

⁵² Китайские иероглифы. Составитель Старостин С. А. Цахим пдф, стр. 1050, 919, 1689

⁵³ Zhengzhang Shangfang. Old Chinese Phonology. Shanghai Educational Publishing House, 2003, pp. 353, 401, 465 (хятадаар)

⁵⁴ Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia. UHP., Honolulu, 2009, 25-31, 7-14

⁵⁵ Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia. UHP., Honolulu, 2009, 1-18, 24-32, 7-14

⁵⁶ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 147, 79, 127

⁵⁷ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 82, 76

мужийн баруун хойд хэсэгт сууж асан Лоуфань (樓煩, loufan, ОС. *g-ro-ban⁵⁸; ОС. *kro-ban⁵⁹), Иньшань (陰山, yinhu, ОС. *qrum61/*qrəm62) уул, Цахар нутгаар байсан Линьху (林胡, linhu, ОС. *g-rum-qa⁶³; ОС. *k.rəm-g⁶⁴) аймгийн нэрс бүгд өмнөө *k/g буюу *к-х-г*-гийн төрлийн гийгүүлэгчтэй байсан нь авиан бичгийн болоод орчин цагийн нангиадач нарын сэргээлтээс харагдаж байна. Үүгээр юу хэлэх гээд байна вэ гэвэл, Учралт профессорын үзэж байгаачлан Люаньтийн өмнө “сэргээлт-үе” авах шаардлагагүйгээр өөрөө дангаараа *q/h/k-ээр сэргээгдэх бүрэн боломжтой. Үүнийг ч аль дээр Э.Пуллиблэнк маш тодорхой харуулсан. Тиймээс Люаньти гэж тэмдэглэж байх үеийн хятад хэлэнд *люань* (孛) утга үсэг угаасаа *х- -тэй хэлэгдэж байсан бололтой.

Тэгэхээр Люаньти гэсэн үгийг *hwràn-téj гэж сэргээсэн Э.Пуллиблэнкийн сэргээлт, Сюйляньтиг *ha-ran-dē (Старостин), *ha-ran-dê/tê (Шюсслер), *q^ha-ran-d^he (Бакстер, Сагар) гэж сэргээсэн эрдэмтдийн судалгааг хамтагтаж хэрэглэж болох нь. Эдгээр сэргээлтийн эхэнд *h/q гийгүүлэгч гарж ирж байгаа нь тус үгийг «алтай ай»-н аль нэг (дипломат шахуу хэллэг, уг нь шууд монгол хэл л дээ) хэлний үүднээс тайлбарлаж болохыг илтгэж байна. Түүнээс гадна, Хүннү-г *Хонграт (*q^hoŋ.nra<t>) гэж тайлбарласан судалгаандаа тулгуурлавал, Люаньти (*hwràn-téj)-ийн уул язгуур нэрийг X/XI-XII зууны *хонгират* нар дотроос хайж болох давуу тал үүснэ.

«Судрын чуулган»-д *хонгират*, тэдний төрлийн бүх овог, аймаг үүсэж гарсан гурван хүүгийн хамгийн бага дүү Тосбодай-гаас **Харанут** (Qaranut), **Хонгли’ут** (Qongli’ut/Кунклиут) хоёр үүссэн гэж бичсэн байдаг.⁶⁵ Санаагаа товч илэрхийлбэл:

Люаньти < Nan. *hwràn-téj < *h^sran^t ~ *haran<u>; **Сюйляньти** < BX. *ha-ran-diē < *haran<u>d; ОС. *qha-ren-te < *q^haran<u>t гэж томъёолмоор байна.

Тиймээс, Люаньти, Сюйляньти хоёр нь *haran<u>/*haran<u>d гэсэн үгийн галиг мөн байна гэсэн санал дэвшүүлж байна. Харин, Харанут нь X/XI-XII зууны монголын нэг томоохон угсаа-улс төрийн бүлэг болох Хонгиратын нэг салбар овог/аймаг билээ.

⁵⁸ Zhengzhang Shangfang. Old Chinese Phonology. Shanghai Educational Publishing House, 2003, pp. 409, 314 (хятадаар)

⁵⁹ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 82, 32

⁶⁰ “Харанхуй” гэдэг утгаас гадна “ам, хавцал хаах” гэх утга бас байдаг бололтой.

⁶¹ William H. Baxter and Laurent Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction. Version 1.1 (20 September 2014), 2014, p. 138

⁶² Старостин, Шюсслер хоёрын сэргээлтийг үндэслэсэн бидний төсөөлөл.

⁶³ Жэнжан Шанфан. Шангу иньси. Ди-эр-бан. Шанхай Цзяюй-шубан-шэ (郑张尚芳. 上古音系. 第二版. 上海教育出版社) 2019, т. 418, 347

⁶⁴ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 80, 51

⁶⁵ Рашид-ад-дин. Сборник летописей. Том I книга первая. Перевод с персидского Л.А.Хетагурова, редакция и примечания А.А.Семенова. М-Л., 1952, стр. 161, 164; Rashiduddin Fazlullah’s. *Jami’u’l-tawarikh: Compendium of Chronicles. A History of the Mongols. Part One. English Translation & Annotation by W.M.Thackston. Harvard University, 1998, pp. 85, 87*

ХУЯНЬ, ЛАНЬ, СЮЙБУ, ЦЮЛИНЬ

Эхний гурван нэр «Түүхийн тэмдэглэл»-д байдаг, сүүлийнх нь «Хожуу Хань улсын бичиг»-т байдаг.⁶⁶

Хуянь. Хуянь гэдэг угсаатны нэрийг эрдэмтэд хэдэн янз тайлбарлаж байсан тоймыг Г.Сүхбаатарын бүтээлээс харж болно. Харин Г.Сүхбаатар өөрөө Хуянийг хамгийн анх хамаг монголын Хиан/Хиад гэдэг угсаатны нэртэй холбож тайлбарласныг ч бүгд мэдэх бөлгөө.⁶⁷

Хүннүгийн Хуянь бол хожмын Хиан юм гэж хэлэхдээ Г.Сүхбаатар, зөвлөлтийн эрдэмтэн С.Е.Яхонтовийн *qayan⁶⁸ гэх сэргээлтэд тулгуурласан.

Хуянь (呼衍)-ий орчин цагийн сэргээлт:	ЛН.	*ha-jan
	ОСМ.	*hâ-jan? ⁶⁹
	ОС.	*q ^h a-qan? ⁷⁰

Эдгээр нь “хүннүгийн хамгийн эрхэм овог болох «хуянь» бол Эргүнэ кунд очсон монголын [яг тухайлбал, Бөртэ чиногийн удмынхны] өвөг овог «хиян» мөн гэж нотлох түүх, хэл, угсаатны бүрэн үндэс”-ийн нэг хэлний чиглэлийн нотолгоо болж “«хуянь», «хиян» гэх хоёр нэрийг нэгэн угсаатны нэгэн нэр мөн болохыг тодорхой харуулж байна.”⁷¹

Бид өмнө нь 2012 онд, Б.Сумьяабаатар (1975), Ч.Догсүрэн (1987)-ий судалгаанд тулгуурлан хиан/хиян/киян (хиад/кияд/хиюд) нэр нь *ki-* язгуур, *-yan/γan/gan* бүтээврээс бүрдэх (*ki+yan/γan = kiyan ~ qi+yan/γan = qiyan*) юм байна хэмээгээд, эрт цагт “цагаан”-ыг илтгэх үг байжээ⁷² гэсэн санал дэвшүүлж байсан билээ.

Лань. Г.Сүхбаатарын бичсэнээр бол анхнаасаа хүннүгийн гурван язгууртан овгийн нэг байсан Лань-ий нэрийг тайлсан судалгаа гэж бараг байхгүй. Яо Вэйюань-ий судалгааг эшилж “*улолань* овог бол хүннүгийн гол дөрвөн овгийн нэг *лань* овог мөн бололтой” гэж Г.Сүхбаатар бичжээ. Тэр *улолань*-ийг нь тюркологич Л.Базен **ulaqlar* гээд “улааны агт/морь” (*cheval de relais*) гэх утгатай түрүү түрэг үг гэж тайлбарласан.⁷³ *Лань* (хүннү), *улолань* (сяньби)-ий холбоосыг шалгах хэрэгтэй, тус нэрийг түүх сударт тэмдэглэсэн үе буюу м.э. III-IV зууны

⁶⁶ Groot J.J.M. de. Die Hunnen der vorchristlichen Zeit. Chinesische Urkunden zur Geschichte Asiens. Erster Teil. Berlin und Leipzig, Walter de Gruyter & Co., 1921, S. 57

⁶⁷ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 182, 197-198

⁶⁸ Сүхбаатар Г. *Сяньби*. УБ., 1971, т. 195, в-15

⁶⁹ Schuessler A. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia*. UHP, Honolulu, 2009, 1-17, 24-29

⁷⁰ Baxter W. and L.Sagart. *Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00)*. 2011, pp. 51, 153

⁷¹ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 197, 198

⁷² Батсүрэн Б. *VI-X зууны монгол аймгууд (түүх-угсаа гарвалын шинжилгээ)*. Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. УБ., 2012, т. 40-43

⁷³ Сүхбаатар Г. *Сяньби*. УБ., 1971, т. 52, №19; Bazin L. *Recherchers sur les parlers T'o-pa (5^e siècles après J.C.) – TP. Second Series. Vol. XXXIX, Livr 4/5, 1950, p. 283*

үеийн дуудлага нь *ʔō.lāk.lān бол Хань улсын үеийнх нь *ʔā.rāk.rān ⁷⁴ гэж байна.			
Лань (蘭, lan) : Хань.	*rān	Лань (蘭, lan) : Хань	*rān ⁷⁵
ОС.	*g·ran	ОС.	*g·ran ⁷⁶
ОСМ.	*rān	ОСМ.	*rān ⁷⁷
ОС.	*k.rʰan	ОС.	*kə.rʰan ⁷⁸

Жэнжан Шанфан, Бакстер, Сагар гурвын лань 蘭/蘭-ий – *g·ran, *k.rʰan, *kə.rʰan – сэргээлт нь, “эртний их өтгөс хаад” гэж улсын эздийг нь хөрш улс, аймгууд нь хүндэлдэг, Хэрэйд улсын долоон аймгийн нэг улсын цөм болох Хэрэйд гэсэн угсаатны нэртэй их төстэй гэж үзэж байна.

Өмнөх нэгэн судалгаандаа *хэрэйдийн* уг шагийг өмнөд хүннүгийн хэлай/хэлань (賀賴, helai; 賀蘭, helan) хүртэл мөшгөж үзсэн. Тус хоёр аймгийн нэрийг галигласан үсгийн 280-400 оны орчмын дуудлагыг судалгаа хэрэглэн *ʔa-rati (ONW+Dm), *ʔa-raʔ (ONW+Bz.) гэж сэргээсэн юм.⁷⁹

Одоо харин тэр судалгаандаа дөрөөлбөл хүннүгийн лань 蘭 овог нь *хэрэйдийн* дээд өвгийн нэг байж болохоор байна. Тааварлавал, Хүннүд байсан лань овог тэргүүт *өвөг-хэрэйдүүд* Хүннү хоёр хуваагдахад нэг хэсэг нь өмнөд хүннүгийн Би шаньюйг дагаж одоогийн Хөх хотын араар Иньшань (Газал уул) нурууны ар, өвөр этгээдэд суужээ.⁸⁰ Тэд хожим табгач сяньбийн Умард Вэй улсад шингэсэн гэж болох ч *табгач* нартай удаан тэмцэлдсэн *хэлай/хэлань* нар *жужантай* хамт говийн арын уугуул нутагтаа буцсаныг, баримтгүй хэмээн шууд үгүйсгэж болохгүй.

Хүннүгийн ард иргэдийн нэг хэсгийг захирагч сурвалжит лань/*kə.ran овог нь монгол угсаатны нэг, томоохон угсаа-улс төрийн нэгдлэг болох *хэрэйдийн* өөрөөр хэлбэл язгууртнуудынх нь дээдэс, өвөг мөн бөгөөд Лань 蘭 бол Хэрэйд нэрийн анхны тэмдэглэл гэсэн санал дэвшүүлж байна.

Сюйбу. Угсаатны нэр судлалын хувьд өнөөг хүртэл тодорхой шийдэлд хүрээгүй, хүннү/qʰoŋ.nraʈ-гийн сурвалжит 4 овгийн нэг нь Сюйбу (須卜, хубу) юм.

Л.Базен 1950 онд сюйбу 須卜-г *sīruq гэж сэргээн “түрүү түрэг хэмээн [үзсэнийг Г.Сүхбаатар] нотолгоогүй” гэж эргэлзсэн.⁸¹ Харин 1992 оны бүтээлдээ Г.Сүхбаатар “Сюйбу нь IX-X зууны хятад сурвалж бичигт «цзубу» (цзупу) гэж, түвд сурвалж бичигт «согбо» гэж тэмдэглэгдсэн гэж эрдэмтэд үзэж байна.

⁷⁴ Китайские иероглифы. Составитель Старостин С. А. Цахим пдф, стр. 690, 1179, 1771

⁷⁵ Китайские иероглифы. Составитель Старостин С. А. Цахим пдф, стр. 1771, 1637

⁷⁶ Zhengzhang Shangfang. Old Chinese Phonology. Shanghai Educational Publishing House, 2003, pp. 368, 369 (хятадаар)

⁷⁷ Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia. UHP, Honolulu, 2009, 23-7

⁷⁸ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, p. 76

⁷⁹ Батсүрэн Б., Дэлгэржаргал П., Эрдэнэбат У. *Монголын эзэнт гүрний түүх*. Тэргүүн боть. Их Монгол улс. Степпе публишинг, УБ., 2019, т. 70-71, 74, 80-81

⁸⁰ Таскин В.С. Материалы по истории сюнну (по китайским источникам). Вып. II. Пер. и прим. М., Наука. 1973, стр. 74, тэнд Динсян-д Ланьши нутаглав гэж бий.

⁸¹ Сүхбаатар Г. *Сяньби*. УБ., 1971, т. 45, №28

Монголыг түвэдээр «согбо» гэнэ” хэмээн бичсэн.⁸² Бичвэрээс харвал, Сюйбу-г хятаны үеийн Зүбү (түвэдийн Согбо) гэсэн нэртэй холбожээ.

Энэ овгийн нэрийг тайлбарлах гол үндэс нь одоохондоо зөвхөн галиг үгийн сэргээлт болж байх шиг байна. Тиймээс Сюйбу (須卜)-гийн сэргээлтийг сонирхъя. Түүний LH. *sio-pok, OSM. *sno-pôk⁸³; OC. *s-no.p^{ok}⁸⁴ ажээ. Сэргээлт нь хүртэл тун бэрхтэй болох нь шууд харагдаж байгаа байх.

Гэхдээ нэгдүгээр үеийн *s- -ийн ард гарч ирж буй *-n- нь эрт цагийн харийн *-r- байх боломжтой, тэгвэл Сюйбу нь *s-ro.pok болох бөгөөд үүнтэй хамгийн ойролцоо угсаатны нэрээр Сяньби хэмээх угсаатны нэрийн язгуур дуудлага *särbi/*servi гэж болох талтай, гэвч ямар ч хүн хараад шууд эргэлзэхээр тун ээдрээтэй гэдгийг бид өөрсдөө ойлгож байгаа боловч ийм боломж өчүүхэн боловч байгаа гэж үзээд түүнийгээ та бүхэнтэй хуваалцаж байна. Бидний харсан гэх тэр боломж нь Жэнжан Шанфаны сэргээлтийн систем, хятад-санскрит орчуулга болон сурвалж, бичгийн дурсгалын мэдээний тайлбар ба өнөөдрийн монголын эртний судлалын нэгэн судалгаатай холбоотой.

Жэнжан Шанфаны сэргээлтийн тольд хоёр сүй 須, 璽 үсэг бий, нэг бүлгийн үсгүүд гэдгийг нь Б.Карлгрений сэргээлтийн толиос харж болно.⁸⁵ Жэнжан Шанфаны сэргээлтээр эхний сүй нь *so харин хоёрдахь нь *sraʔ гэж сэргээгдэнэ. Хоёрдахь хувилбарыг хэрэглэх аваас Сюйбу нь *sraʔ-pog⁸⁶ болох ба *s<ɣ.b< гэх хэлбэр агуулж мэдэхээр байгаа юм, үүнд л найдсан.

Хожуу Хань улсын нийслэлд, 150-220 онд орчуулсан санскрит зэрэг хэлний буддын нэг сударт sro- гэсэн үеийг хятад руу xi- (須)-гээр оноож буулгасан байдаг.⁸⁷ Эл жишгээр бол Сюйбу нь *sro-pok гэсэн үгийг галиг гэдэг нь улам боломжтой болсон.

Сурвалж бичгүүдэд *сүйбугийн* тухай “хожим гарсан *сүйбу* ... сурвалжит овог [юм,] баруунд орох [ө.х. баруун гарт хамаарах] *сүйбу* овог нь шүүхийн хэргийг эрхлэн ял оноож, тэр тухайгаа шаньюйд амаар илтгэнэ, гэхдээ бичиг, дэвтэр үйлдэхгүй”⁸⁸ гэж тэмдэглэсэн байдаг.

Харин, монголын археологичид сүүл үеийн судалгаагаараа Эрдэнэт орчмын Айргийн гозгорт, I-IV зуунд холбогдох бүлэг булштай дурсгал илрүүлж судлаад *сяньби* нарынх байх гэсэн.⁸⁹

⁸² Сүхбаатар Г. *Монголын түүхийн дээж бичиг*. Тэргүүн дэвтэр. УБ., 1992, т. 19, тайлбар 3

⁸³ Schuessler A. *Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensa*. UHP, Honolulu, 2009, 10-30, 11-22

⁸⁴ Baxter W. and L.Sagart. *Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00)*. 2011, pp. 147, 10

⁸⁵ Karlgren B. *Grammata Serica Recensa – The Museum of Far Eastern Antiquities. Bulletin No. 49*. Stockholm, 1957, 133 а ба 133 f-ийг харьцуулна уу.

⁸⁶ Жэнжан Шанфан. Шангу иньси. Ди-эр-бан. Шанхай Цзяюй-шубан-шэ (郑张尚芳. 上古音系. 第二版. 上海教育出版社) 2019, т. 524, 291

⁸⁷ Coblin, South W. *A Handbook of eastern Han Sound Glosses*. Hong Kong, The Chinese University Press, 1983, BTD. 19

⁸⁸ Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 54-55; Сүхбаатар Г. *Монголын түүхийн дээж бичиг*. Тэргүүн дэвтэр. УБ., 1992, т. 18, 20

⁸⁹ Одбаатар Ц. *Сяньбичүүдийн оршуулгын зан үйлийн асуудалд – Сяньби, Жужаны үеийн түүх, соёлын судалгаа*. ЭШХ-ын эмхэтгэл. Эмхэтгэсэн Ц.Одбаатар, Ц.Эгиймаа. УБ., 2018, т. 6-24

Сюйбу-тай холбоотой бичгийн сурвалжийн *хожим гарсан* гэдэг мэдээний он цагийг багцаалж болно. Өргөн хүрээгээр бол – *дунхучууд* Модун шаньюйд ялагдсан м.э.ө. 208.хавар/207.намраас, «Түүхийн тэмдэглэл»-ийг Сыма Цянь бичиж дуусгасан м.э.ө. 90-ээд оны хооронд холбогдоно. Он цагийн хамрах хүрээг хумьж багцаалбал – Хүннү гүрэн ихэд хүчирхэгжиж эхэлсэн м.э.ө. II зууны эхний хориос-гучаад жил (м.э.ө. 190-170/160) гэж багцаалж болох талтай.

Археологийн судалгааны үр дүн болон сурвалжийн мэдээний он цагийн хамаарлын талаарх санал маань – сюйбу/*s-ro.pok бол *сэрби/сэрви нэрийн нэг хувилбар байх гэсэн саналд өчүүхэн боловч боломж байгааг харуулах бас нэг үндэс хэмээн үзэхэд хүргэсэн.

Өөрөөр хэлбэл, м.э.ө. II зууны эхэн хагаст, дунхугийн удмын бусад сурвалжит овгоо бодвол хүннүгийн эрх баригч нартай илүү ойр харилцаатай сяньбийн нэгэн овог хэлхээ холбоондоо тулгуурлан, статусаа ахиулж хүннүгийн дөрвөн язгууртан овгийн хэмжээнд хүрчээ. Гэрч нь Эрдэнэт хот орчмын Айргийн гозгорын дурсгал ч байж болно. Яагаад гэвэл *сюйбу* нь хүннүгийн баруун гарт харьяалагдаж байсан ба баруун гарын гол төв нутаг нь одоогийн Архангай аймаг хавь гэж бид таамагладаг. Түүнчлэн, Хүннүд ирж, төрийн эрх мэдлийг атгалцаж эхэлсэн эл *сяньби* овог, м.э. II зуунд Сяньбийн нэгдсэн улсыг байгуулсан Сухэ⁹⁰ (*sa^huai/*sa^hwai) овогтой заавал холбогдох албагүй гэдгийг цохон тэмдэглэж байна.

Цюлинь. «Хожуу Хань улсын бичиг»-т “шаньюй *сюйляньти* овогтон, бусад овогтон [болох] *хуянь* ураг, *сюйбу* (хэйбу) ураг, *цюлинь* (циолинь) ураг, *лань* ураг, дөрвөн овог улс дотроо алдар цуутай төрөл, шаньюйн овогтой олонтоо ураг барилдана”⁹¹ гэсэн мэдээ бий.

«Түүхийн тэмдэглэл»-д дурдсан гурван язгуурт овог дээр Цюлинь (Циолинь, K’u-lim) гэдэг овог нэмэгджээ. Г.Сүхбаатар “Хүннү улсад бүр эхний үед *хуянь* (хожмын монгол сурвалжийн киян), *лань* хоёр, дараа нь *сюйбу*, нилээд сүүл үед *цюлинь* эдгээр дөрвөн овог нь улсын сурвалжит аймагт тооцогдож ...”⁹² байсан гэж гарч ирсэн дарааллаар дурджээ. «Хань улсын бичиг»-т тэмдэглэгдээгүй байхыг бодоход тус овог м.э. тавиад оноос хойш өмнөд хүннүгийн сурвалжит овгийн зэрэгт хүрсэн ба умард хүннүгийн язгуурт овог болсон эсэхийг магадлах боломж одоогоор бараг л алга.

Цюлинь (丘林, qiulin)-ийг *küriin гэж Л.Базен сэргээж, ордосын *küriin*, сонгодог монголын *kürän*(g) “хүрэн” гэсэн үг гэжээ.⁹³

⁹⁰ Энэ сурвалжит овог хожим *хятан* нарт шингэсэн байх. Батсүрэн Б. Сяньби (Сэрби/Сэрви)-ийн Сухэ (suhe) овгийн тухай – *Сяньби, Жужаны үеийн түүх, соёлын судалгаа*. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018, т. 25-28

⁹¹ Хоуханьшу, 89, Наньсюнну, 2944-2945; Groot J.J.M. de. Die Hunnen der vorchristlichen Zeit. Chinesische Urkunden zur Geschichte Asiens. Erster Teil. Berlin und Leipzig, Walter de Gruyter & Co., 1921, S. 57; Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 55

⁹² Сүхбаатар Г. *Монголчуудын эртний өвөг*. УБ., 1980, т. 84-85

⁹³ Bazin L. Recherchers sur les parlers T’о-ра (5^e siècles après J.C.) – TP. Second Series. Vol. XXXIX, Livr 4/5, 1950, p. 245

Цюлинь-ий сэргээлт:	ЛН.	*k ^h wə-lim ~ k ^h u-lim
	Хань.	*khəw-rəm ⁹⁴
	ОС.	*kh ^w u-g-rum ⁹⁵
	ОСМ.	*khwə-rəm ⁹⁶
	ОС.	*k ^{wh} ə-k.rəm ⁹⁷

Эдгээр сэргээлтээс харвал “хүрэн” (*kürin) гэхээс илүүтэй, м.э.ө. III-I зууны үед *k^ho.rən гэж дуудагдах боломжтой мэт санагдана. Тус сэргээлтээр бол «Судрын чуулган»-ы Хори аймаг байж болох юм. Ингэж үзсэн шалтгааны нэгээр дараах түүхэн баримтыг дурдъя.

Жоло буюу Налайхын голын уудам хөндийд ирж буугаад Нирун улсын төрд шинэчлэл хийж, дараа нь хавь ойрын аймгуудыг довтолж байсан Жарун (Шэлуны) хааныг Жибаетжи гэдэг хүннүгийн үлдэгдэл баян хүчирхэг аймаг довтлон ирэхэд нь тосож байлдан бутцохиод аймгийг нь нэгтгэсэн түүхтэй.⁹⁸ Жибаетжи гэдэг нэрийг бид Йер Байырку гэж үзсэн.⁹⁹ Байырку аймаг бол 740-өөд онд Уйгурын төрд гавьяа байгуулж, тэдний эзэн нь уйгурын хааны дараах хоёр том эрх мэдэлтний нэг нь болж байсан хүчирхэг угсаа-улс төрийн нэгдлэг бөгөөд X-XII зууны *баргут* мөн гэж үздэг. «Судрын чуулган»-д *баргут*, *хори* хоёрыг төрөл, элгэн садан аймгууд гэж тэмдэглэсэн. «Монголын нууц товчоон»-ы *хори түмэдийн* «түмэд»-ийг «Судрын чуулган»-д *баргутын* салаа салбар гэсэн байдаг. Ингэхлээр *хори* нь *баргутаар* дамжаад нируны үеийн улмаар “хүннүгийн үлдэгдэл” гэх баримтаар дөрөөлж бүр цаашлан хүннүгийн үе хүрнэ гэсэн үг. Энэ л холбоос, шижмийг харгалзан Цюлинь (Кулим) овгийг хожмын Хори байх гэж таамагласан юм.

ТӨГСГӨЛ

Харь улсын түүхэнд галиглаж үлдээсэн хүннү нарын угсаатны нэр мөн хүннү нарт хамаарах өөр хэдэн нэрийг тааварлаж сэргээхийг зорьсон оролдлогоо дахиж товчилж хүргэе:

хүннү <*q^hoŋ.nra(t)>,
 люаньти/сюляньти <q^haran<u>/haran<u>d>,
 хуянь <qayan/kiyan>, (энэ оноолт бидний санал биш гэдгийг дахин хэлье)
 лань <kereyit/d>,
 суйбу <s<>rb<>/särbī>,
 цюлинь/кулим <khōrən/qōrī>

⁹⁴ Китайские иероглифы. Составитель Старостин С. А. Цахим пдф, стр. 83, 396

⁹⁵ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 461, 418

⁹⁶ Schuessler A. Minimal Old Chinese and Later Han Chinese. A Companion to Grammata Serica Regensia. UHP., Honolulu, 2009, 4-14, 38-18

⁹⁷ Baxter W. and L.Sagart. Baxter-Sagart Old Chinese reconstruction (Version 1.00). 2011, pp. 105, 80

⁹⁸ Сүхбаатар Г. Монгол Нирун улс (330 орчим–555 он). УБ., 1992, т. 12-13

⁹⁹ Батсүрэн Б. Монголчуудын уг гарвал – Танин мэдэхүйн цуврал-3. УБ., 2015, т. 39

Эдгээр цөөхөн сэргээлтээр бол хүннүгийн үеийн *төв/дотоод азийнхны* овгуудын ихэнх нэрийг монгол хэлний үүднээс тайлбарлах боломжтой нь харагдахын хамт уулаас ийм байх ёстой ч байж мэднэ. Гэхдээ *хүннүчүүд* лав энэ хавийн түүхэнд өмнө нь үзэгдэж харагдаагүй том эзэнт улс байгуулсан учраас янз бүрийн хэлтэн овгууд Хүннү гүрэнд багтаж байсан билээ. Тухайлбал – *тохарууд* болох *усунь* <asiavoi/asiani>; *скифүүд* болох *хуньюй*=*хунье* <skula>, *цуйшэ* <skuda> нар хийгээд *эртний өндөр тэрэгтэн* буюу *огузууд* болох *динлин* <tägräg>, *синьли* <sg.il/izgil>, *хуге/угйе* (uigur/oγur/z), *гэкунь/гяньгунь* <qirgur/qurquγ> нарыг нэрлэмээр байна. Гэвч, Хүннү гүрний хүн амын дийлэнхийг монгол угсаатнууд бүрдүүлж байсан нь хөдөлбөргүй үнэн. Өвөг *хүннүчүүд* хэмээн андуурч нэрлэсээр байгаа Ордос, Иньшань, Хэсийн хонгилын жинхэнэ эзэд – *лоуфань* <kro.ban/kro.han>, *линьху* <krom.γa>, *байян*, *сютугэ*, *луху* зэрэг нь бидний үзэхээр тохар эсвэл энэтхэг-европын бусад төрөл хэлээр ярилцагч овгууд болно. Мөн Хүннү гүрэнд захирагдаж, м.э.ө. тавиад онд хүннүгийн хаан ширээний төлөөх өрсөлдөөнд хүртэл оролцож байсан *ушаньму* (кадыр?), *уже* (эдиз?) нар нь өндөр тэрэгтний салбар овог байх магадлал тун өндөр. Ингэснээр Хүннү гүрний харьяанд байсан өндөр тэрэгтнүүдийн тоо дөрөв тав биш харин долоо найм болж өсөж байгаа ба тэд *жинхэнэ хүннү* нартай улс төрийн холбоотой болохоос бус хэл, соёл, угсаа гарвалиар арай ангид овгууд байсан гэдгийг тууштай түрэгчдээс бусад нь хүлээн зөвшөөрөх байх.

Сүүлийн үед гадаадын зарим судлаач – *ухуань* ба *сяньби* нарыг манж-тунгус нартай холбож үзэж байсан XIX зууны өрнөдийн, улирсан онолыг сэргээх гэж оролдох болжээ. Тэдний баримталж байгаа үзэл үндсээрээ буруу болохыг харуулахын тулд доор цөөн хэдэн *авар/ухуань* хүний нэрийн сэргээлтийг хавсаргаж толилуулья.

1. Туньтоу	ОС. *tun.do, ЗХ. *ʈwən.dhwā	*todo/*tödö
2. Хань	РДК. *hār	*qara
3. Хэдань	ЛН. *hak.tan	*qatan / хатан [болд]
4. Синьжибэнь	ОС. *qʰəm.tə.pʰur < *kə.tə.bür	*хэтэбүри?
5. Тадунь	ЛН. *dap.tuən < *da.tuər	*tatar (Э.Паркерийн санал)
6. Кюлигюй	ЛН. *kʰu.lik/lək.kia < *ku.lək	*küleg
7. Лоубань	ВХ+ЛН. *rwā.pan < *ar.ban	*arban
8. Наньлоу	ВХ. *nān.rwā < *nā.rā	*naran
9. Супуянь	ArC. *so.bʰuk.dian < *su.bu.dai ~ *su.buγ.dai	*sübeʼetei
10. Уянь	ЛН. *ʔa.jan < *q.jan	*хиан
11. Коулоудунь	EMC. kʰəwʰ.ləw.twən < *qu.lu.tan	*qulutan?
12. Алугян	EMC. ʔa.la.tsian < *qa.ra.caγ	*qarcaγai
13. Хулю	EMC. γəʰ.luw	*quluγu ~ *külügü
14. Уучэнь	СК. mü.müt.din < *bübüdi	*bübei<dei> ~ бүүвэй

< bübürdi	*bübür ~ бүвэр?	
15. Гилюжюань	СК. zjit.lük.kwén < *ji.rü.ken	*jirüke<n>
16. Вэньян	EMC. mun.ʔiaŋ < *mun.qaŋ	*muŋqay
< *bur.qaŋ	*burqan ~ burqan	
17. Мобэй	EMC. mat.pəj < *babai	*babai~ баавай
18. Гэхүгү/Гэуту		*qaraqāda

Эдгээр 18 хүний нэр монгол үг байгаа нь жинхэнэ авар (ухуань)-уудын багтдаг дунху, Дунхугийн нэг том салбар болох, ухуань нарын төрөл садан сяньбичуудыг сүүл үед гадаадын эрдэмтэд тунгус гэж үзэж буй нь бас л углуурга нь аль эрт муудсан байшинг засаж өнгөлж байгаагаас өөрцгүй явдал болохыг харуулж байна. Сяньбийг ингэж үзсээр удаж байгаа тэдгээр нэр өндөр эрдэмтэн нар эл үгэнд маань гомдохгүй байх гэж найдаж байна.

Abstract

Over the past seventy years, less than ten foreign researchers have tried to reconstruct the ancient pronunciation of two hieroglyphs, which are now pronounced as Xiongnu, and determine the origin of this ethnonym. But they believed that «Xiongnu» was either a transliteration of «huna», «hwōnhná», «hunga», «xoŋai», while some of them believed that it was a purely Saka, that is, an Iranian ethnonym. Others thought it was the name of the river (Hoŋi/Ongi). In our opinion, both concepts strongly contradict the history of the peoples of Inner Asia, and this immediately becomes obvious when studying their research, but their one conclusion, that the ethnonym is apparently not Turkic in origin, indicates that the Turkic origin should be excluded from the search for the root of the Xiongnu name. Through two recent studies, we have been able to explain the Xiongnu ethnonym. Our work was based on a 2011/2014 study by W.Baxter and L.Sagart, which showed that the second syllable -nu in the ethnic name of the Xiongnu is *nʰa, as well as a study by A.Schuessler in 2009, which, in our opinion, indicates that 奴 nú (=女ǚ) – can also be reconstructed as *nraʔ. In other, by reconstructing the syllable -nu as *nra(t/d) or *ra(t/d), we came to the conclusion that the name *qʰoŋ.rat/*hoŋ.rad or Qongirat/Hongirat of the 12th–13th centuries is the root word of the ethnonym «Xiongnu». By the way, I started writing a monograph on the history of the Xiongnu almost a dozen years ago, and my monograph begins with this idea. For some reason, I didn't have time to finish it, and the work on the monograph dragged on for several years. Therefore, we decided to share with the readers our opinion on the origin of the Xiongnu ethnonym.